

МОНГОЛ-ГЕРМАНЫ ХОЖУУ ҮЕИЙН ХАРИЛЦАА (1950-1990 ОН)

*Д.Уламбаяр**

Дэлхийн хоёрдугаар дайны дараа социализм системийн хувьд бүрэлдэн тогтохын хамт БНМАУ-ын гадаад бодлого шинэ агуулгаар баяжин хөгжсөн билээ. БНМАУ шинэ тутам буй болсон социалист орнуудтай тус орны харилцааг хөгжүүлэн бэхжүүлэх, улс төр, эдийн засгийн хамтын ажиллагааны агуулга хэлбэрийг өргөжүүлэх, олон улсын тавцан дээр хамтран ажиллах бодлого явуулж иржээ.

I. Улс төрийн харилцаа

1950 оны 4-р сарын 13-нд БНМАУ-ын ГЯЯ-ны сайд, БНАГУ-ын ГЯЯ-ны сайд нар өөрсдийн засгийн газруудыг төлөөлж ноот солилцсоны дүнд тус хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоогдсон байна.¹ Анхны элчин сайдаар сүүлд /1956/ ГЯЯ-ны сайд болсон Д.Адилбиш томилогдон Берлинд очиж БНАГУ-ын анхны ерөнхийлөгч Вильгелм Пикт итгэмжлэх жуух бичгээ барьжээ.

БНМАУ, социалист орнуудын хооронд дипломат харилцаа тогтсон явдал тус орны хувьд ч, нийт социалист системийн хувьд ч тухайн үедээ чухал ач холбогдолтой үйл явдал байв.

БНМАУ 1957 оны 8-р сард БНАГУ-тай найрамдал, хамтын ажиллагааны тухай 6 зүйл бүхий гэрээ (энэ гэрээг 1968 оны 9-р сард сунгажээ) байгуулсан нь нэн шинэ зүйл болов. Энэхүү гэрээнд Ю.Цэдэнбал тэргүүтэй БНМАУ-ын засгийн газрын төлөөлөгчид Берлинд айлчлах үеэрээ гарын үсэг зурсан юм.² Айлчлалын үеэр мөн хоёр засгийн газрын хооронд Соёл, шинжлэх ухааны талаар хамтран ажиллах тухай 9 зүйл хэлэлцээр байгуулсан нь монгол оюутан, аспирант, мэргэжил дээшлүүлэгчид 1958 оноос БНАГУ-д суралцах үүдийг нээжээ. Үүнээс гадна Монголын ЗГ-ын төлөөлөгчид ХБНСЮУ, БНБАУ, БНСРУ, БНУАУ, БНСЧСУ, БНПАУ-д тус тус айлчилсан нь Европын социалист орнуудад хийсэн албан ёсны анхны айлчлал байснаараа онцлог байлаа. Айлчлалын үеэр хийсэн хэлэлцээрийн үр дүнд хамтарсан мэдэгдэл, албан мэдээ гаргаж, улс орнуудын ард түмний найрамдалт харилцааг хөгжүүлж, дэлхийн социалист системийг бэхжүүлэх асуудлаар санал солилцжээ.

1950-иад оны дунд үеэс эхлэн социалист орнуудын засгийн газрын төлөөлөгчид БНМАУ-д айлчлах болсны тод илрэл нь БНАГУ-ын ерөнхий сайд Отто Гротеволь тэргүүтэй төлөөлөгчид 1955 оны

*Д.Уламбаяр - МУИС-ийн Олон улсын харилцааны сургуулийн ахлах багш

12-р сард Улаанбаатарт айлчилсан явдал байлаа.³ Айлчлалын дүнд хамтран гаргасан албан мэдээнд алдарт таван зарчмыг сэтгэл ханамжтай тэмдэглэсэн байна. Үүнд:

1. Нутгийн бүрэн бүтэн байдал, бие биенийхээ тусгаар тогтнолыг харилцан хүндэтгэх,
2. Харилцан үл довтлох,
3. Бие биенийхээ дотоод хэрэгт үл оролцох,
4. Тэгш эрх, харилцан ашиг тустай байх,
5. Энх тайвнаар зэрэгцэн орших эдгээр зарчим болно.

1955 онд ГНСН-ын ТХ-ны 1-р нарийн бичгийн дарга В.Ульбрихт манай оронд айлчилсан бол Ю.Цэдэнбал тэргүүтэй МАХН-ын төлөөлөгчид БНАГУ-д айлчлав. Айлчлалын үеэр нам, төрийн тэргүүнүүд хоёр орны аж ахуй, соёлын байгуулалтын ололт амжилттай харилцан танилцаж, туршлага солилцон хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар бодитой алхам хийсэн юм.

1957 оны 9-р сард Монголын парламентын бүлгэм байгуулагдаж үйл ажиллагаа нь БНМАУ болон янз бүрийн орны парламентуудын хооронд холбоо, харилцаа тогтоон хөгжүүлэх, улс түмнүүдийн хоорондын харилцан ойлголцох, найрамдах явдлыг бүх талаар бэхжүүлэхэд чиглэгдэж иржээ. Энэ үеэс социалист бусад орнуудтай парламентын төлөөлөгчид харилцан солилцох нь улс төрийн хамтын ажиллагааны нэг чухал хэлбэр болсон билээ. 1958 онд БНМАУ-ын АИХ-ын төлөөлөгчид БНАГУ-д, 1959, 1969 онд БНАГУ-ын парламентын төлөөлөгчид Монголд, 1968 онд БНМАУ-ын парламентын төлөөлөгчид БНАГУ-д тус тус айлчилжээ.

1960 оны 1-р сард ГНСН-ын ТХ-ны УТТ-ны гишүүн, БНАГУ-ын СнЗ-ийн орлогч дарга, Гадаад ба Герман дундын худалдааны Яамны сайд Хенрих Рау тэргүүтэй засгийн газрын төлөөлөгчид Монголд айлчилж Ю.Цэдэнбал тэргүүтэй нам засгийн удирдах нөхөлтэй хэлэлцээ хийжээ.⁴ Хэлэлцээний үеэр хоёр тал найрсаг харилцааг цаашид цуцалтгүй бэхжүүлэн өргөтгөх чин сэтгэлийг удирдлага болгон, БНМАУ, БНАГУ-ын засгийн газар 1961-1965 онуудад харилцан бараа нийлүүлэх тухай удаан хугацааны худалдааны хэлэлцээр ойрын үед байгуулахаар тохиролцсон байна. БНАГУ нь БНМАУ-ын Засгийн газрын хүсэлтийг хүлээн авч, 1961-1963 оны дотор Улаанбаатар хотод мах комбинат байгуулахад чин сэтгэлийн тусламж үзүүлэхэд бэлэн байгаагаа илэрхийлж протоколд гарын үсэг зуржээ.

1960 оны 5-р сард МАХН-ын ТХ-ны УТТ-ны гишүүн, БНМАУ-ын АИХ-ын тэргүүлэгчдийн дарга Ж.Самбуу БНАГУ-д төрийн найрсаг айлчлал хийж, ГНСН-ын ТХ-ны 1-р нарийн бичгийн дарга Вальтер Ульбрихт, БНАГУ-ын СнЗ-ийн даргын үүрэг гүйцэтгэгч Хенрих Рау,

БНАГУ-ын Ардын Танхимын Тэргүүлэгчдийн даргын үүрэг гүйцэтгэгч Эрнест Хольденбаум нартай яриа хэлэлцээ явуулж, хоёр талын харилцаа болон олон улсын өргөн хүрээтэй асуудлаар санал солилцсон нь чухал ач холбогдолтой үйл явдал болсон байна.⁵

1960-1980-аад онуудад хуралдаж байсан МАХН, ГНСН-ын Их хурлуудад хоёр тал өндөр дээд хэмжээний зочид төлөөлөгчдийг илгээж байсан нь хамтын ажиллагааны чухал хэлбэр байлаа.

II. Худалдаа, эдийн засгийн харилцаа

БНМАУ, БНАГУ-ын хооронд бараа нийлүүлэх болон төлбөрийн тухай Засгийн газрын анхны хэлэлцээрийг 1956 оны 12-р сарын 30-нд байгуулжээ. Хоёр орны хооронд 1959 онд бараа нийлүүлэх тухай 1958 оны 11-р сарын 20-нд, 1960 оны худалдааны протоколыг 1959 оны 8-р сард тус тус байгуулсан байна. Дурьдсан хэлэлцээр, протоколын үндсэн дээр БНМАУ, БНАГУ-ын хооронд худалдааны харилцаа түргэн хөгжиж иржээ. БНМАУ-аас БНАГУ-д тэмээ, хонь, ямааны ноос, ноолуур, мах, өлөн гэдэс, ангийн үс нийлүүлж, оронд нь радио хүлээн авагч, оёдлын машин, гэрэл зургийн аппарат, унадаг дугуй, цахилгаан хэрэгсэл, эмнэлгийн төхөөрөмж, бөс даавуу, сүлжмэл эдлэл зэрэг барааг худалдаж авч байлаа.

БНМАУ, БНАГУ-ын хоорондын худалдааны бараа эргэлт (мян.руб)

| | 1957 | 1958 | 1959 | 1960 | 1957-1960 | 1960:1957 % |
|------------------------------|---------|---------|---------|---------|-----------|-------------|
| Нийт бараа эргэлт | 14131,9 | 18076,3 | 22467 | 26979,4 | 81654,6 | 1,9 дахин |
| а) Экспорт | 9113,1 | 9486,5 | 12064,0 | 10774,5 | 41438,1 | 1,2 дахин |
| б) Импорт | 5018,8 | 8589,8 | 10403,0 | 16204,9 | 40216,5 | 3,2 дахин |
| Үүнээс | | | | | | |
| - Өргөн хэрэглээний бараа | 2986,4 | 6127,1 | 7597,5 | 12613,5 | 29324,5 | 4,2 дахин |
| - Машин, төхөөрөмж, материал | 2032,4 | 2462,7 | 2805,5 | 3591,4 | 10892,0 | 1,8 дахин |

Эх сурвалж: БНМАУ-ын УААА 40 жилд. Статистикийн эмхтгэл. УБ., 1961, 128-130 дахь тал

Хоёр орны худалдааны нийт бараа эргэлт 1960 онд 27 сая руб. хүрч, 1957 оныхоос 1,9 дахин өсчээ. Өргөн хэрэглээний барааны импорт энэ хугацаанд 4,2 дахин өсч, импортын нийт дүнд 1960 онд 77,8 хувийг эзлэх болсон явдал хоёр орны худалдааны нэг онцлог байлаа.

БНМАУ, БНАГУ-ын хоорондын худалдаа 1961-1965 онд хоёр орны засгийн газруудын хооронд 1960 оны 7-р сарын 8-нд байгуулсан урт хугацааны хэлэлцээрийн дагуу цаашид өргөжин хөгжив.

БНМАУ, БНАГУ-ын хоорондын худалдааны бараа эргэлт (сая.руб)

| | 1960 | 3-р таван жил | | | | | 1961- 1965 | 1965:1960 % |
|---------------------------|------|---------------|------|------|------|------|---------------|----------------|
| | | 1961 | 1962 | 1963 | 1964 | 1965 | | |
| Нийт бараа эргэлт | 6,1 | 6,5 | 4,2 | 3,9 | 5,0 | 4,9 | 24,5 | 80,3 |
| а) Экспорт | 2,4 | 3,7 | 2,4 | 2,1 | 1,9 | 2,1 | 12,2 | 87,5 |
| б) Импорт* | 3,7 | 2,8 | 1,8 | 1,8 | 3,1 | 2,8 | 12,3 | 75,7 |
| Үүнээс | | | | | | | | |
| - Өргөн хэрэглээний бараа | 3,0 | 1,7 | 1,0 | 1,2 | 2,3 | 2,2 | 8,4 | 73,3 |
| - Аж үйлдвэр | 0,7 | 1,1 | 0,8 | 0,6 | 0,8 | 0,6 | 3,9 | 85,7 |

Эх сурвалж: БНМАУ-ын УААА 45 жилд. Статистикийн эмхтгэл. УБ., 1966, 129 дэх тал
**Зээлээр нийлүүлсэн барааны дун ороогуй.*

Худалдааны урт хугацааны хэлэлцээр ёсоор БНМАУ жилд дунджаар 3 мянган тонн үхэр, хонины мах, 200 тонн хонины халуун угаалгын ноос, 300 тонн тэмээний ноос, 200 гаруй мянган гогцоо өлөн гэдэс, 70 мянган ширхэг тарваганы арьс, 30 мянган ширхэг хонины арьс, 400 тонн цөцгийн тос, 200 тонн яс, махны гурил зэрэг барааг БНАГУ-д экспортолжээ.

1965 оныг 1960 онтой харьцуулахад БНАГУ-д нийлүүлсэн өлөн гэдэс 2,4 дахин, тарваганы арьс 1,8 дахин, туулайн арьс 2 дахин, хонины арьс 2 дахин, мах, ясны гурил 2 дахин тус тус өссөн байна. Үүнээс гадна жил бүрийн худалдааны протокол ёсоор 1961-1965 онд БНАГУ-д хурга, ишигний арьс, адууны дэл сүүл, сарлагийн сүүл, хялгас, ямааны хялгас зэрэг барааг мөн экспортолжээ.

БНАГУ-аас лаборатори, цахилгааны болон хүн эмнэлгийн тоног төхөөрөмж, химийн бараа, будаг, мотортой дугуй, унадаг дугуй, радио хүлээн авагч, оёдлын машин, гэр ахуйн цахилгаан хэрэгсэл, зургийн аппарат, хивс, сүлжмэл эдлэл, бэлэн хувцас зэрэг барааг импортлож байв. 1965 оныг 1960 онтой харьцуулахад БНАГУ-аас худалдаж авсан оёдлын машины тоо 2,1 дахин, унадаг дугуй 1,3 дахин, моторт дугуй 2 дахин, гэрэл зургийн аппарат, киноны багаж хэрэгсэл 2 дахин, химийн бүтээгдэхүүн 3,3 дахин, хөгжмийн хэрэгсэл 26 хувь, угаалгын бодис 1,9 дахин, хивсний зүйл 1,3 дахин тус тус нэмэгдсэн байна.

Жил бүрийн протокол ёсоор гүн хэвлэлийн үйлдвэрийн зориулалттай химийн бараа, нэхэх машин, цахилгаан гэрэлтүүлэгч, трансформатор, нэхмэлийн болон хүнсний төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, өндөр даралтын уурын тогоо, сүүний машин, түүнчлэн гоо сайхны болон спортын хувцас хэрэгсэл, төрөл бүрийн сам, сойз, цаг, гэр ахуйн цахилгаан хэрэгсэл, гоёл чимэглэлийн зүйлс, хүүхдийн тоглоом зэрэг

барааг БНАГУ-аас худалдан авчээ. Өргөн хэрэглээний бараа БНАГУ-аас 1961-1965 онд худалдан авсан барааны нийт үнийн дүнд 68,3 хувийг эзлэж байв.

БНМАУ, БНАГУ-ын хооронд 1964 оны 6-р сарын 27-нд байгуулсан хэлэлцээрээр БНАГУ-ын Засгийн газраас БНМАУ-ын Засгийн газарт 3 сая рублийн өргөн хэрэглээний барааны зээл олгосон байна. Хэлэлцээрт зээлийн төлбөрийг 1971-1975 онд жил бүр адил тэгш хэмжээтэйгээр Монголын экспортын уламжлалт барааг БНАГУ-д нийлүүлэх журмаар гүйцэтгэхээр тохиролцжээ.

Хэлэлцээр ёсоор БНАГУ 1964, 1965 онд 1 сая метр хувцасны даавуу, 400 мянган рублийн нэхмэлийн бараа, 40 мянган м.кв хивс, 100 мянган м.кв мебелийн даавуу, 400 мянган рублийн сүлжмэл эдлэл, оймс, 210 мянган хавтгай дөрвөлжин метр ширээний хулдаас, 55 мянган рублийн химийн бүтээгдэхүүн, 500 ширхэг радио хүлээн авагч, 400 ширхэг баян хуур хөгжим, 250 ширхэг гал тогооны мебель, 10 ширхэг хими цэвэрлэгээний машин болон бусад өргөн хэрэглээний барааг Монгол улсад нийлүүлсэн байна.

БНМАУ, БНАГУ-ын хооронд 1966-1970 онд харилцан бараа нийлүүлэх болон төлбөрийн тухай хэлэлцээрийг 1965 оны 9-р сарын 28-нд байгуулжээ.

Түүнчлэн хоёр орны хооронд харилцан солилцох барааны нэр төрөл, хэмжээ болон төлбөрийг жил бүрийн протоколд тодорхойлон зааж байв. Үүний үндсэн дээр хоёр орны худалдааны бараа эргэлт 1966-1970 онд өмнөх 5 жилийнхээс 14,6 хувь, үүний дотор экспорт 31,9 хувиар өссөн дүн гарчээ.

БНМАУ, БНАГУ-ын хоорондын худалдааны бараа эргэлт (сая.руб)

| | 1966 | 1967 | 1968 | 1969 | 1970 | 1966-1970 | 1966-1970 ----- % 1961-1965 |
|---------------------------|------|------|------|------|------|-----------|-----------------------------------|
| Нийт бараа эргэлт | 4,4 | 4,9 | 5,6 | 5,5 | 7,7 | 28,1 | 114,6 |
| а) Экспорт | 2,4 | 3,1 | 3,4 | 3,3 | 3,9 | 16,1 | 131,9 |
| б) Импорт | 2,0 | 1,8 | 2,2 | 2,2 | 3,8 | 12,0 | 97,5 |
| Үүнээс | | | | | | | |
| - Өргөн хэрэглээний бараа | 1,4 | 1,4 | 1,9 | 1,8 | 3,1 | 9,6 | 114,3 |
| - Техникийн бараа | 0,6 | 0,4 | 0,3 | 0,4 | 0,7 | 2,4 | 61,5 |

Эх сурвалж: БНМАУ-ын УААА 50 жилд. Статистикийн эмхтгэл. УБ., 1971, 138 дахь тал

БНМАУ, БНАГУ-д 1966-1970 онд халуун угаалгын ноос, тэмээний ноос, ямааны ноолуур, хялгас, адууны дэл сүүл зэрэг мал аж ахуйн гаралтай түүхий эд нэлээд хэмжээгээр нийлүүлж байсан бөгөөд тэдгээр бараа нь 5 жилд экспортын барааны үнийн нийт дүнд 76 хувийг

эзлэж байв. Төрөл бүрийн савхин эдлэл, ноосон хөнжил, мах, махан бүтээгдэхүүн зэрэг хөнгөн хүнсний үйлдвэрийн бүтээгдэхүүн тус улсаас БНАГУ-д 5 жилд нийлүүлсэн барааны үнийн нийт дүнд 21 хувийг эзлэх болсон байна.

БНАГУ-аас Монгол улс мах комбинат, хивсний үйлдвэрийн тоног төхөөрөмж, хэвлэлийн үйлдвэрийн машин, сэлбэг хэрэгсэл, суудлын вагон, эмнэлэг, лаборатори, гэрэл зургийн хэрэгсэл, тооны болон бичгийн машин, гэр ахуйн цахилгаан хэрэгсэл, будаг, ноосон даавуу, сүлжмэл эдлэл, оймс, гүн хэвлэлийн цаас, хивс зэрэг бараа голчлон импортложээ. БНАГУ-аас тус улсад 1966-1970 онд гадаад худалдааны шугамаар нийлүүлсэн барааны үнийн нийт дүнд өргөн хэрэглээний болон хүнсний бүтээгдэхүүн 80,0 хувь, төрөл бүрийн машин, төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл 20,0 хувийг эзлэх болжээ.

БНМАУ, БНАГУ-ын харилцан худалдаа нь хоёр орны Засгийн газрын хооронд 1971 оны 1-р сарын 15-нд байгуулсан худалдааны урт хугацааны хэлэлцээрийн үндсэн дээр цаашид ч өргөжин хөгжсөн юм. Худалдааны эргэлт 1971-1975 онд 58,3 сая рубльд хүрч, өмнөх 5 жилийнхээс 2,1 дахин өссөний дотор, экспорт 1,9 дахин, импорт 2,2 дахин нэмэгдсэн байна. БНМАУ, БНАГУ-д уламжлалт хонины халуун угаалгын ноос, тэмээний ноос, ямааны ноолуур, хялгас, мах, хивс, төрөл бүрийн савхин болон нэхий эдлэл, бусад бараа, бүтээгдэхүүн экспортложээ. Эдгээр барааны үнийн дүнгийн 61,4 хувийг хөнгөн хүнсний үйлдвэрийн бүтээгдэхүүн эзлэх болжээ.

БНМАУ, БНАГУ-ын хоорондын худалдааны бараа эргэлт (сая.руб)

| | 1971 | 1972 | 1973 | 1974 | 1975 | 1971-1975 | 1971-1975 |
|---------------------------|------|------|------|------|------|-----------|----------------------|
| | | | | | | 1975 | ----- % 1966-1970 |
| Нийт бараа эргэлт | 8,9 | 9,6 | 11,9 | 13,4 | 14,5 | 58,3 | 207,4 |
| а) Экспорт | 4,5 | 5,6 | 6,9 | 7,4 | 6,8 | 31,2 | 193,8 |
| б) Импорт | 4,4 | 4,0 | 5,0 | 6,0 | 7,7 | 27,1 | 225,8 |
| Үүнээс | | | | | | | |
| - Өргөн хэрэглээний бараа | 3,2 | 2,9 | 3,8 | 4,1 | 4,8 | 18,8 | 195,8 |
| - Техникийн бараа | 1,2 | 1,1 | 1,2 | 1,9 | 2,9 | 8,3 | 345,8 |

Эх сурвалж: БНМАУ-ын УААА 55 жилд. Статистикийн эмхтгэл. УБ., 1976, 91 дэх тал

БНАГУ-аас дотуур, гадуур хувцас, фото зургийн хэрэгсэл, соёл ахуйн бараа зэрэг нэлээд олон нэрийн өргөн хэрэглээний бараа худалдан авч байсан бөгөөд энэ нь 5 жилийн импортын дүнд 69,5 хувь эзлэж байлаа. Түүнээс гадна БНАГУ-аас төрөл бүрийн машин,

тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл худалдан авсан нь өмнөх 5 жилийнхээс 2,8 дахин өссөн байна.

БНМАУ, БНАГУ-ын хоорондын эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагаа тус хоёр орны найрамдал, хамтын ажиллагааны тухай гэрээ (1968 оны)-ний үндсэн дээр өргөжин хөгжиж ирэв. ГНСН-ын ТХ-ны 1-р нарийн бичгийн дарга Эрих Хонеккер тэргүүтэй БНАГУ-ын нам, төрийн төлөөлөгчид 1973 онд тус улсад албан ёсны найрсаг айлчлал хийж, Монголын нам, засгийн төлөөлөгчидтэй нөхөрсөг яриа хэлэлцээ явуулсан нь БНМАУ, БНАГУ-ын найрамдалт харилцаа, тал бүрийн нягт хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэн бэхжүүлэхэд чухал ач холбогдол болсон байна.⁶

БНАГУ-ын засгийн газар социалист эдийн засгийн интеграцийн Цогцолбор программын заалтын дагуу БНМАУ-ын эдийн засгийн хөгжилд тусламж үзүүлэх зорилгоор Улаанбаатарын мах комбинат, бусад барилга байгууламжийг барин, шинэчлэн өргөтгөх, ХАА-г хөгжүүлэх, геологи хайгуулын ажил хийхэд олгосон зээлийн бүх өрийг Монгол улсаар төлүүлэхгүйгээр шийдвэрлэсэн бөгөөд ингэснээр БНАГУ нь БНМАУ-д их хэмжээний буцалтгүй тусламж өгсөн юм. Мөн Эрнест Тельманы нэрэмжит Борнуурын сангийн аж ахуйн засварын газарт зориулан иж бүрэн тоног төхөөрөмжийг бэлэг болгон шилжүүлсэн байна.

Цогцолбор программын заалтын дагуу БНМАУ-ын ХАА, боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүнд гадаад худалдааны урамшлын үнэ хэрэглэх тухай Монголын засгийн газар ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудад хүсэлт тавьсан бөгөөд уг асуудлаар хоёр талын хэлэлцээ БНАГУ болон бусад хамтын нөхөрлөлийн орнуудтай хийсний үр дүнд тус улсын экспортын зарим төрлийн бүтээгдэхүүнд (мах, мал, ноос, хайлуур жонш) урамшлын нэмэгдэл контрактын шинэ үнэ тогтоосон байна.

Түүнээс гадна Ардын хувьсгалын 50 жилийн ойг тохиолдуулан БНАГУ орчин үеийн машин техникээр тоногдосон хивсний үйлдвэрийг Монголын талд бэлэглэсний дээр БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ойгоор 4,6 сая маркын өргөн хэрэглээний барааг үнэ төлбөргүй нийлүүлжээ.

БНМАУ, БНАГУ-ын нам засгийн төлөөлөгчдийн дээр дурьдсан хэлэлцээний үр дүнд хоёр орны эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэх чиглэлийг тодорхойлсон юм. Тухайлбал:

- Тус улсын экспортын нөөцийг нэмэгдүүлэхийн тулд геологи хайгуулын хамтарсан ажлыг үргэлжлүүлж, нээж олсон эрдэс түүхий эдийг ашиглах

- ХАА, юуны өмнө мал аж ахуйг хөгжүүлэх талаар хамтын ажиллагаагаа өргөтгөх

- БНАГУ-ын техникийн туслалцаатай байгуулсан мах комбинат, хивсний үйлдвэрийн хүч чадлыг бүрэн эзэмших
- Малын ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор мал эмнэлгийн арга хэмжээ авах зэрэг зүйлийг төлөвлөн заасан байна.

БНАГУ-ын техникийн туслалцаатай Монголын барилгын байгууллагын хүчээр 1972 онд Улаанбаатарын мах комбинат ашиглалтанд оржээ. Комбинатын бүрэлдэхүүнд анхан шатны боловсруулалт хийх үйлдвэр, өлөн гэдэсний завод, хөргөлтийн аж ахуй, техникийн тос, альбулины үйлдвэр, арьс давслах цех, хиам, консервын завод, яс боловсруулах үйлдвэр болон ахуй үйлчилгээний барилга байгууламжууд багтаж байв. Комбинат мах, өлөн гэдэс, ясны гурил, төрөл бүрийн дайвар бүтээгдэхүүн, 20 нэр төрлийн хиам, 10 төрлийн консерв үйлдвэрлэж, комбинатын бүтээгдэхүүнийг дэлхийн 20 орчим оронд гаргаж байсан юм. Үйлдвэрийн ашиглалтын үеийн ажилчдыг БНАГУ-д дадлагажуулж, мэргэжлийг нь дээшлүүлсний зэрэгцээ уригдаж ажиллаж байсан мэргэжилтнүүд монгол ажилчдыг газар дээр нь бэлтгэх, тэдэнд дадлага, туршлага эзэмшүүлж, туслалцаа үзүүлж байлаа.

Жилд 350 мянган м.кв хивс үйлдвэрлэх чадалтай Улаанбаатарын хивсний үйлдвэр 1974 онд ашиглалтанд оржээ. Үйлдвэрлэсэн “Алтанбулаг”, “Улаанбаатар”, “Солонго” хивс нь олон улсын үзэсгэлэн яармагуудад амжилттай оролцож, “Алтан медаль” дипломаар шагнагдаж байлаа. Үйлдвэрийн өргөтгөлийн ажлыг ч БНАГУ-ын туслалцаатайгаар гүйцэтгэжээ.

БНАГУ манай ХАА-н салбарыг хөгжүүлэхэд зориулан ихээхэн туслалцаа үзүүлж байлаа. 1976-1980 онд Борнуурын сангийн аж ахуйд 150 тракторын засварын газар, 2000 тн багтаамжтай төмсний агуулах, 1000 тн бордооны агуулах, 320 хүүхдийн сургууль, 140 ортой цэцэрлэг-ясли, 15 ортой их эмчийн салбар зэрэг соёл ахуйн барилга байгууламж иж бүрнээр баригдаж ашиглалтанд оржээ.

Малын паразиттай тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд үзүүлсэн тусламжаар үхрийн арьсны гуур, бэлчээрийн хачиг, хонины экстроз, адууны гастрофилес зэрэг малын өвчнийг оношлон, эмчлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

БНАГУ-ын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр улсын хэвлэлийн комбинатын гүн хэвлэлийн цех, мах комбинатын өргөтгөлд шаардлагатай тоног төхөөрөмж, материал нийлүүлэгдэж, Улаанбаатарын Универсам, ШУТ-ын мэдээллийн төвийг барихад өөрийн хувь хөрөнгийг оруулах зэрэг туслалцаа үзүүлжээ.

1981-1985 онд БНАГУ-ын техникийн туслалцаатай Улаанбаатар хотын ногоо дахин боловсруулах цехийг ашиглалтанд оруулж, Улаанбаатар хотын шаазан ваарын үйлдвэрийн өргөтгөл,

шинэчлэлийн ажлыг гүйцэтгэхийн зэрэгцээ буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Борнуурын сангийн аж ахуйд холбооны автомат станц, цэвэрлэх байгууламж, гунж бойжуулах ферм, үрийн төмсний агуулах барьж, түүнчлэн БНАГУ-ын их дээд сургуулиудад монголын 370 оюутан, 30 аспирант, ТМС-д 690 охид, хөвгүүдийг сургах, 1000 ажилчдын мэргэжил дээшлүүх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэв.

1981-1985 онд зээлээр 540 мэргэжилтэн уригдан ажиллаж, манай 1250 хүнийг БНАГУ-д явуулж, мэргэжлийг нь дээшлүүлжээ. Монгол улс БНАГУ-ын их, дээд сургуулиудад 1958 оноос оюутан сургаж эхэлсэн бөгөөд 1990 оны байдлаар 20000 гаруй оюутан төгсчээ.

Хоёр орны бараа гүйлгээний хэмжээ ч ихээхэн өсч байв. БНМАУ, БНАГУ-д мах, лаазласан мах, хонины халуун угаалгын ноос, адууны хөөвөр, тарваганы арьс, өлөн гэдэс, зэсийн баяжмал, хивс, савхин болон нэхий эдлэл зэрэг бүтээгдэхүүн гаргаж, машин, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, өргөн хэрэглээний бараа худалдан авчээ.⁷

БНМАУ-аас БНАГУ-тай хийсэн гадаад худалдааны нийт эргэлт 1980 онд 76 сая, 1985 онд 147,6 сая, 1988 онд 124 сая төгрөг болж ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын дотор ЗХУ, БНСЧСУ-ын дараа 3-р байрт орж байв.⁸

БНАГУ-аас Монголд 1970 онд 1,3 мянган жуулчин ирж байсан бол 1980 онд 1,8 мянга, 1988 онд 2,3 мянган жуулчин болж өссөн байна.⁹

Гадаад худалдааны Монголэкспорт нэгдэл 1960-аад оноос Лейпцигийн олон улсын ангийн үсний үнэ хаялцах худалдаанд 20 гаруй нэрийн (улаан үнэг, тарвага, шилүүс, чоно, туулай, хэрэм г.м) ангийн болон зөөлөн үстний арьстайгаар жилдээ 4-7 удаа оролцож, чөлөөт валютаар худалдаа хийж, 2 сая ам.долларын ашиг олж байжээ.¹⁰

БНАГУ манай улсын нутаг дэвсгэрт ажиллаж байгаа олон улсын геологийн экспедицийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байлаа. БНАГУ-ын геологийн экспедиц Хэнтий, Баянхонгор аймаг, Бороо, Зуунмод, Хар-Ямаат, Сүжигт, Нарантолгойн орд газар эрэл хайгуулын ажлыг гүйцэтгэсний дүнд жонш, алт, гянтболд зэрэг ашигт малтмалын орд газрын нөөцийг тогтоож, хоёр орны холбогдох байгууллагуудын хооронд эрдэс түүхий эдийн зарим орд газрыг эзэмших асуудлаар хэлэлцээ хийж байв.

Хоёр орны хоорондын ШУТ-ын салбар дахь хамтын ажиллагаа өргөжиж, харилцан сонирхсон сэдвээр шинжилгээ, судлагаа хийх, үр дүнг харилцан мэдээлэх, мэргэжилтэн солилцох, үндэсний боловсон хүчин бэлтгэхэд чиглэгдэж байлаа. Хоёр орны эрдэм шинжилгээний байгууллагууд нэг наст болон олон наст ургамал тариалах, байгалийн болон таримал өвсийг манай нөхцөлд бэлтгэх асуудлаар судалгаа хийх, малын паразиттай тэмцэх биобэлдмэл бэлтгэх талаар судалгаа хийж,

зарим туршлагыг үйлдвэрлэлд нэвтрүүлж ирсэн нь сүүний гарцыг нэмэгдүүлэх, өвс тэжээлийг чанартай хадгалах, малын элдэв өвчнөөс сэргийлэхэд ихээхэн ач холбогдолтой болсон юм.

БНАГУ-ын нам, төрийн төлөөлөгчид Монгол улсад 1986 онд айлчлах үеэр БНМАУ, БНАГУ-ын эдийн засаг, ШУТ-ын хамтын ажиллагааг 2000 он хүртэл үргэлжлүүлэх урт хугацааны гэрээнд гарын үсэг зурсан байна.

Ер нь БНАГУ нь социалист орнуудын дотор эдийн засгийн чадавхиараа өндөрт тооцогдож байсан бөгөөд Монгол улсын боловсруулах үйлдвэрийн салбарыг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэжээ. БНМАУ, БНАГУ-ын социалист интернационализмын зарчимд тулгуурласан найрамдалт харилцааны 40 жилийн түүх нь 1990 оноос хойш Монгол улс Нэгдсэн Герман улстай харилцаагаа бүх талаар эрчимтэй хөгжүүлэхийн шимтэй хөрс болсон гэдгийг тэмдэглэвэл зохино.

Дэлхийн хоёрдугаар дайны дараа Герман хоёр хэсэгт хуваагдсан нь “Хүйтэн дайн”-ы үр уршиг байсан билээ. 1949 оны 9-р сарын 7-нд америк, англи, францын эзэмшлийн бүсийн нутаг дээр ХБНГУ байгуулагдаж, ардчилал, зах зээлийн эдийн засгийг тууштай баримталж, нээлттэй бодлого явуулснаар дэлхийн нөлөө бүхий гүрэн болсон нь тодорхой юм.

БНМАУ, ХБНГУ-тай дипломат харилцаа тогтоох болсны эх сурвалж нь Холбооны канцлер, социал-демократ Вилли Врандтын явуулсан “Остполитик”-той юуны өмнө холбоотой. Вилли Врандт ХБНГУ “Бүх Германыг төлөөлөх цорын ганц улс” гэсэн зарчмаасаа татгалзаж, 1970 онд ХБНГУ ба ЗХУ, ХБНГУ ба БНПАУ-ын гэрээнд гарын үсэг зурж, уг гэрээнд Европ дахь хил хязгаар, түүний дотор Одер-Нейсийн хил ХБНГУ ба БНАГУ-ын хоорондын хилийг халдашгүй гэдгийг батлан хүлээж, Гэрээ 1972 оны 6-р сарын 3-наас хүчин төгөлдөр болжээ. ХБНГУ, Чехословак, Болгар, Унгартай харилцаагаа хэвийг болгож, дипломат харилцаа тогтоон, баруун Берлиний асуудлаар 4 гүрний хэлэлцээр байгуулж, улмаар 1973 онд хоёр Герман НҮБ-д адил тэгш эрхт, хууль ёсныхоо суудлыг эзэлсэн нь “Остполитик”-ын гол үр дүн байв.

Тийнхүү Европт буй болсон нааштай уур амьсгал БНМАУ, ХБНГУ-ын хооронд 1974 оны 1-р сарын 31-нд дипломат харилцаа тогтоох нөхцлийг бүрдүүлжээ. Дипломат харилцаа тогтоосноос хойш 1990 он хүртэл хоёр орон 1986, 1988 онд байгуулсан Соёлын хамтын ажиллагааны хэлэлцээр болон протоколыг эс тооцвол худалдааны харилцаатай явж иржээ.

Энэ хугацаанд БНМАУ-ын экспорт, импортын нэгдлүүд ХБНГУ-д ан олзворын бүтээгдэхүүн, бугын ясан эвэр, тарваганы тос, цаа бугын

цусан эвэр, ноос зэрэг барааг гаргаж, суудлын “Мерседес Бенз” автомашин, түүний сэлбэг, шүдэнзийн фабрикийн тоног төхөөрөмж, нэхмэлийн үйлдвэрийн сэлбэг, арьс ширний идээлгийн материал, химийн бараа, эм, магнитфон, түүний хуурцаг, пянз, спортын бараа, бичгийн цахилгаан машин зэрэг барааг импортлож байжээ. 1980-аад оноос хийжэхэлсэн худалдааны нийт эргэлт 1989 оны эцэст 18.8 сая дойчмарк, үүнээс экспорт 74, импорт 11.4 сая болсон нь өрнөдийн орнууд дотроо дээгүүрт тооцогдож байв.¹¹

Улс төрийн шинэ сэтгэлгээ, өөрчлөн байгуулалт олон улсын харилцааны гол хандлага болсноор 1990 онд Берлиний хана нуран унаж, хоёр Герман нэгдэн Нэгдсэн Герман улс байгуулагдсан түүхэн үйл явцтай, Монголд ардчилсан хувьсгал тайван замаар явагдаж, хуучин социалист систем эцэс болж, улс орон ардчилал, чөлөөт зах зээлийн эдийн засагт шилжин, нээлттэй, олон тулгуурт гадаад бодлого явуулах болсон үйл явц цаг хугацааны хувьд давхацсанаар Монгол-Германы харилцаа түүхэн шинэ нөхцөлд нийцэн эрчимтэй хөгжих болсон билээ.

Монгол Улсын анхны ерөнхийлөгч 1995 онд анх удаа ХБНГУ-д төрийн айлчлал хийж “Монгол Улс, ХБНГУ-ын харилцааны үндсийн тухай тунхаглал” хэмээх тулгуур баримт бичиг байгуулсан нь өрнөдийн орнуудтай харилцааны ерөнхий зарчим, үндсийг тодорхойлсон анхны үндсэн баримт бичиг болж хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааны эрх зүйн суурь үндэс болсон юм. “Монгол Улс, ХБНГУ-ын хооронд хөгжиж ирсэн найрсаг харилцаа, хамтын ажиллагааг тус хоёр орны ард түмний сайн сайхны тулд цаашид хөгжүүлэх, олон улсын энх тайван, аюулгүй байдлыг бататган хамгаалах, улс түмний хоорондын харилцан итгэлцэл, эв найртай хамтран ажиллах үйлсэд хувь нэмэр оруулах зорилгын үүднээс Монгол Улс, ХБНГУ ёслол төгөлдөр” тунхаглаж “Монгол Улс, ХБНГУ НҮБ-ын дүрэм болон олон улсын эрхзүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн түгээмэл зарчим, хэм хэмжээг баримтлан, харилцаа, хамтын ажиллагаагаа цаашид бататган хөгжүүлнэ” гэжээ.¹²

2002 онд Монгол Улсын Ерөнхий сайд ХБНГУ-д айлчилж, Холбооны канцлертай хэлэлцээ хийх үеэрээ Монгол, Германы харилцааг Шинэ Мянганд чиглүүлж, иж бүрэн түншлэлийн түвшинд хүргэх чин эрмэлзэлтэй байгаагаа анх удаа албан ёсоор мэдэгдсэн нь¹³ хоёр орны харилцааны өнөөгийн хүрсэн түвшин, ирээдүйг илтгэсэн нэн чухал ач холбогдолтой үйл явдал болов.

Эцэст тэмдэглэхэд Европын Холбооны жинтэй, нөлөө бүхий гишүүн ХБНГУ бол Монгол Улсын гуравдахь чухал түнш мөн.

ИШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. БНМАУ-ын гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэл. 1-р боть, (1921-1961) УБ., 1964, 13 дахь тал
2. БНМАУ-ын гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэл. 1-р боть, (1921-1961) УБ., 1964, 40 дэх тал
3. БНМАУ-ын гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэл. 1-р боть, (1921-1961) УБ., 1964, 125 дахь тал
4. БНМАУ-ын гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэл. 1-р боть, (1921-1961) УБ., 1964, 222 дахь тал
5. БНМАУ-ын гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэл. 1-р боть, (1921-1961) УБ., 1964, 235 дахь тал
6. ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын олон талын хамтын ажиллагаа. УБ., 1977, 58 дахь тал
7. Д.Галсандорж, Х.Буд. Монгол улсын эдийн засгийн гадаад харилцаа. УБ., 2001, 85-87 дахь тал
8. БНМАУ-ын эдийн засаг, нийгмийн хөгжил-1988 онд, Статистикийн эмхтгэл. Уб., 1989, 107 дахь тал
9. Мөн тэнд 106 дахь тал
10. БНМАУ-ын гадаад худалдааны хөгжилт. УБ., 1981, 138 дахь тал
11. “Гадаад харилцаа” ГХЯ-ны товхимол, 1998.09.07, №15 (43)
12. Монгол улс, ХБНГУ-ын харилцааны танилцуулга, ГХЯ, УБ., 1996
13. “Гадаад харилцаа” ГХЯ-ны мэдээллийн товхимол, 2003. 2 сар. №4 (128), 19 дахь тал